



ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 25-Т/29

Улаанбаатар хот

“ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ”-ЫН УДИРДЛАГАД ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

Дүгнэлт

Бид “ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ”-ын /цаашид нам гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланда аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ”-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн гаргасан Сангийн сайдын заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү аудитын тайлангийн Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус Намаас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлох зүйл нь бидний дүгнэлтэд зохицтой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно. Цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэсэн төсөөллөөр тайлангаа бэлтгэсэн байна.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Хиймөрь хотхон, 4-7 байр, 7-1 тоот
Утас: 91160110, 95957791
И-Мэйл: info@mindug.mn, director@mindug.mn

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлангт жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Бусад мэдээлийн хувьд удирдлага хариуцах бөгөөд жилийн санхүүгийн тайланд орсон боловч бидний гаргасан аудиторын тайланд ордоггүй. Бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилт гаргадаггүй.

Санхүүгийн тайланд засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу гаргаж, үнэн зөв толилуулах нь бидний үүрэг хариуцлага бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь намын тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, намаа татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бodoх бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь намын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг, хариуцлага бид хийж гүйцэтгэсэн аудитаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг бидиээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил болно. Аудитын явцад тус намд хэрэглэгдэж байгаа нягтлан бodoх бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бodoх бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлангуудын бодитай эсэхэд үнэлэлт өгөв. Мөн бид мэргэжлийн үл итгэх байдлыг баримтлан ажилласан. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авна.

- Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг орно.
- Намын дотоод хяналтын үр ашигтай байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаарх ойлголт олж авдаг.
- Намын ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол, тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Намын тасралтгүй байх зарчимд материаллаг тодорхойгүй байдалд эргэлзээ үүссэн бол тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулж, тодруулгад хангалттай дурдаагүй бол дүгнэлтээ оорчлөх шаардлагатай болдог. Аудитын тайлан гарах одөр хүртэл олж авсан баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргасан.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж, санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлсон.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Улс төрийн намын тухай” хууль /шинэчилсэн найруулга/-ын 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Сонгуулийн төв байгууллага болон тус улс төрийн намын удирдлагад зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮРДҮН, ЦАР ХҮРЭЭ

Нэг. Үндэслэл

Улс төрийн намын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д “Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланда аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина” гэж заасан.

Хоёр. Зорилго

“Миндүг Аудит” ХХК нь Намын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэл, бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн холбогдох Аудитын Олон Улсын Стандартын дагуу шалгаж, баталгаажуулан дүгнэлт тайлан гаргана.

Гурав. Хүрэх үр дүн

Улс төрийн намын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.-д “Нам жилийн эцсийн санхүүгийн тайлангаа жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан аудит хийсэн санхүүгийн тайланг Сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу намуудын санхүүгийн тайланда аудит хийж хуульд заасан хугацаанд сонгуулийн төв байгууллагад хүргүүлсэн байх ба Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.

Дөрөв. Аудитын ажлын цар хүрээ

Бид аудитын явцад Аудитын Олон Улсын Стандарт, Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, заавар журам, аргазүй, мөн Аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайллагнах журам, Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайллагнах, мэдээлэх, хяналт тавих журам, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, сум, нийслэл дүүргийн сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар аудит хийж, дүгнэлт гарган баталгаажуулсан.

ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Эрсдлүүдийг дараах байдлаар тодорхойлсон: Үүнд:

1. Хандивлагч болон хандивын орлого хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй байх,
2. Үйл ажиллагааны зардал зориулалтын дагуу үнэн зөв, илэрхийлэгдээгүй байх, хангалттай зохистой нотлох баримтаар дэмжигдээгүй байх,
3. Эд хөрөнгө, намын зардалтай холбоотой авлага, өглөгийн тайлангийн мэдээлэл үнэн зөв, бодитой байх,
4. Намын санхүүгийн тайлагнал болон нягтлан бodoх бүртгэлтэй холбоотой дотоод хяналтыг үнэлэх, хяналтын эрсдэл болон материаллаг сул тал оршиин байгаа эсэхийг тодорхойлох,
5. Санхүүгийн тайланда тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв тусгагдаагүй байх

МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Санхүүгийн тайлангийн холбогдох тоон үзүүлэлтүүд нь залilan эсвэл алдаанаас хамааралтайгаар буруу илэрхийлэх явдал үүсэх магадлтай байдаг бөгөөд энэхүү буруу илэрхийлсэн дүн нь санхүүгын тайланда үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт дангаараа эсвэл бүхэлдээ нөлөө үзүүлээр магадлалтай бол "Материаллаг" гэж тооцдог. Аудитын ажлын төлөвлөлт болон гүйцэтгэлийн үе шатанд эрсдлийн түвшин, нийт хөрөнгө, нийт орлого, татварын өмнөх болон дараах цэвэр ашиг, үйл ажиллагааны цар хүрээ, ажил гүйлгээний дүн зэрэг хүчин зүйлсүүдээс хамааруулан материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Намын нийт хөрөнгө болон нийт орлогын аль их дүнг суурь болгон 2 %-иар, гүйцэтгэлийн материаллагийн түвшинг 75%-иар, аудитын буруу тайлагналын босго /AMPT/-ыг нийт материаллагийн 5%-иар тус тус тооцлоо.

Нийт материаллагийн түвшин 69,684,716 төгрөг, гүйцэтгэлийн материаллагийн түвшин 52,263,537 төгрөг, AMPT 3,484,236 төгрөг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ХҮЛЭЭН АВСАН МЭДЭГДЭЛ

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2025 оны 02-р сарын 13-ны өдрийн Улс төрийн намын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын СЕХ/20250103003 дугаар гэрээ Багц №7-ийн санхүүгийн тайлан хүлээлцэх актыг үндэслэн тус намын санхүүгийн тайланг /Хуудасны тоо / хүлээн авсан.

- 1.Үйлчлүүлэгч байгууллагын нэр: "ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ"
2. Улсын буртгэлийн дугаар: 8012103216
3. Регистрийн дугаар: 8489254
4. Үйл ажиллагааны чиглэл: - Улс төрийн намын үйл ажиллагаа
5. Удирдлага буюу даргын нэр: Ц.Оюунгэрэл
6. Удирдлага буюу захирлын харилцах утасны дугаар: 99115109
7. Ерөнхий менежерийн нэр: М.Мөнхцэцэг
8. Харилцах утасны дугаар: 99051481
9. Санхүүгийн тайлан ирсэн огноо: 2025.02.13

Тайланг хүлээлгэн өгсөн: СЕХ-ны УТНСХГ-ын референт О.Очгэрэл 99270909

АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, СОРИЛ ТҮҮНИЙ ҮР ДҮН

№	Шалгах асуудал, горимууд	Тийм/үгүй
1	Хандивлагч болон хандивын орлого хуульд заасан шаардлага, шалгуур хангасан эсэх	Тийм
2	Үйл ажиллагааны зардлууд нь зориулалтын дагуу үнэн зөв, хангалттай зохистой нотлох баримтаар дэмжигдсэн эсэх	Тийм
3	Сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн гаргаж, баталгаажуулсан эсэх	Тийм
4	Намын өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх	Тийм
5	Эд хөрөнгө, намын зардалтай холбоотой авлага, өглөгийн тайлангийн мэдээлэл үнэн зөв, гэрээ байгуулж баталгаажуулсан эсэх	Тийм
6	Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв тусгагдсан эсэх	Тийм
7	Намын санхүүгийн тайлагнал болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дотоод хяналтыг үнэлэх, хяналтын эрсдэл болон материаллаг сүл тал оршин байгаа эсэх	Тийм

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ
ХУУЛЬ БОЛОН БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

1ан

Р

1

9

)

-

.

№	Аудитаар илрүүлсэн зүйлс	Тийм/үгүй
1	Мэргэжлийн, орон тооны нягтлан бодогчтой эсэх	Үгүй
2	НББББ-тай эсэх	Үгүй
3	Орлого хүлээн авахдаа нэг дансаар дамжуулан хүлээн авсан эсэх	Тийм
4	Хуулиар хориглосон этгээдээс хандив авсан эсэх	Үгүй
5	Сонгуулийн зардлын тайлан гаргаж Төрийн аудитын байгууллагад тайлагнасан эсэх	Тийм
6	Татварын хуулийн дагуу холбогдох татварын тайлангуудыг гаргаж Татварын албанад тайлагнасан эсэх	Үгүй
7	Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан эсэх	Үгүй

2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Лав	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31	(төгрөгөөр)
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3	5,426,577	3,338,329	
Авлага	4	-	-	
Бараа материал	5	2,899,100	4,255,100	
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	-	-	-	
Нийт эргэлтийн хөрөнгө		<u>8,325,677</u>	<u>7,593,429</u>	
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө (цэвэр)	7	-	660,000	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	6	-	-	
Нийт эргэлтийн бус хөрөнгө		<u>-</u>	<u>660,000</u>	
НИЙТ ХӨРӨНГӨ		<u>8,325,677</u>	<u>8,253,429</u>	
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР				
Дансны өглөг	8	1,145,000	-	
Бусад богино хугацаат өр төлбөр	8	12,000,000	12,000,000	
Урьдчилж орсон орлого	8	-	-	
Нийт өр төлбөр		<u>13,145,000</u>	<u>12,000,000</u>	
Эздийн өмч				
Дүрмийн сан	9	-	-	
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	9	(4,819,323)	(3,746,571)	
Нийт эздийн өмч		<u>(4,819,323)</u>	<u>(3,746,571)</u>	
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		<u>8,325,677</u>	<u>8,253,429</u>	

'эмэлт тодоруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.

2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний одроор дуусгавар болсон жилийн

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

	Лав	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31	(төгрөгөөр)
Үндсэн үйл ажиллагааны орлого				
Намын гишүүний татвар	10	12,572,790	163,302	
Сонгуульт гишүүний татвар	10	-	-	
Менгэн хандив	10	21,209,977	69,521,414	
Төрийн санхүүжилт	10	-	-	
Төрөөс үзүүлсэн шууд бус дэмжлэг	10	-	-	
Төслийн санхүүжилт	10	-	-	
Намын өөрийн орлого	10	-	-	
Үйл ажиллагааны орлогын нийт дүн		33,782,767	69,684,716	
Үйл ажиллагааны зардал				
Ажилласдын зардал	11	-	-	
Үйл ажиллагааны урсгал зардал	11	39,589,016	19,552,370	
Төрийн санхүүжилтын зардал	11	-	-	
Нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих сурга	11	-	-	
Намын гишүүдийн болон иргэдийн боловсролыг				
дээшлүүлэх сургалтын зардал	11	-	-	
Судалгаа хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	11	-	-	
Сонгуулийн зардал	11	-	49,059,594	
Бусад үйл ажиллагааны зардал	11	-	-	
Үйл ажиллагааны зардлын нийт дүн		39,589,016	68,611,964	
Үйл ажиллагааны үр дүн (1-2)		(5,806,249)	1,072,752	
Бусад олз	12	-	-	
Бусад гарз	12	-	-	
Татварынномиох ашиг, алдагдал		(5,806,249)	1,072,752	
Орлогын татварын зардал	13	-	-	
Татварын дараах ашиг, алдагдал		(5,806,249)	1,072,752	
Зогсоосон үйл ажиллагааны орлого, зардал	14	-	-	
Тайлант үеийн ашиг, алдагдал		(5,806,249)	1,072,752	
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн		-	-	

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.

Y
M
H
I
X
T
T
F
M
A
N
B
A
T
S
D
D
B
A
T
D
D
B
A
T
R
E
L
E
R
I
G
O
I
A
V
C
A
U
Y
Y
T
G
G
E
B
,

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам

2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний одроор дуусгавар болсон жилийн

ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙН ТАЙЛАН

Аудитлагдсан тайлан

(төгрөгөөр)			
Хязгаарлахгүй ноши	Хязгаардаалтай ноши	Эзлийн өмчийн бусад хэсэг	Хурийтлагдсан ашиг
2023 оны 12 дугаар сарын 31	-	-	986,926
Нягтлан бодох бургээлийн боллогын өөрчлөлтийн нөлөө, алдааны задруулга	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(5,806,249) (5,806,249)
Залруулсан Үндэгдэл	-	-	(4,819,323) (4,819,323)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	1,072,752
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Нягтлан бодох бургээлийн боллогын өөрчлөлтийн нөлөө, алдааны задруулга	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
2024 оны 12 дугаар сарын 31	-	-	(3,746,571) (3,746,571)

Нэмэлт тодоруулгууд нь эдгээр салхуургийн тайланын салшгүй хэсэг болно.

2023 болон 2024 оны 12 дугаар сарын 31-тийн одирор дуусчилгар болсон жилийн

МОНГОН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	(тогтолцоо)	
	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Үндсэн үйл ажиллагааны монгон гүйлгээ		
Монгон орлогын дүн	46,927,767	69,684,716
Намын гишүүний татвар	12,572,790	163,302
Иргэний өгсөн мөнгөн хандив	34,354,977	69,521,414
Хуулийн этгээдийн өгсөн мөнгөн хандив	-	-
Төрийн санхүүжилт	-	-
Төслийн санхүүжилт	-	-
Өөрийн хөрөнгийг захиран зарцууллах замаар олсон орлого	42,488,116	69,967,964
Монгон зарлагын дүн		
Ажилчдад төлсөн		
Нийтийн даатгалын байгууллагад төлсөн	2,899,100	1,356,000
Бараа материал худалдан авахад	19,552,370	-
Ашиглалтын зардалд төлсөн	39,589,016	-
Түвшн шатахуун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсэдд төлсөн	-	49,059,594
Сонгуулийн зардал	-	-
Татварын байгууллагад төлсөн	-	-
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнтэн зарлага	4,439,651	(283,248)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр монгон гүйлгээний дүн		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны монгон гүйлгээ		
Монгон орлогын дүн		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
Монгон зарлагын дүн		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр монгон гүйлгээний дүн	(660,000)	
Санхүүгийн үйл ажиллагааны монгон гүйлгээ		
Монгон орлогын дүн		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Гишүүдээс оруулсан хөрөнгө		
Монгон зарлагын дүн		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Хувьцаа будаан худалдаж авахад толсон		
Төлсөн ногдол ашиг		
Бусад		1,145,000
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр монгон гүйлгээний дүн		
Валютын ханшийн зөрүү		(1,145,000)
Бүх цэвэр монгон гүйлгээ	4,439,651	(2,088,248)
Монго, түүнтэй адилтгах хоронгийн эхийн үлдэгдэл	986,926	5,426,577
Монго, түүнтэй адилтгах хоронгийн эцсийн үлдэгдэл	5,426,577	3,338,329

Нэмээлт тодоруулжүүд нь эдэээр санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.

НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТАЛААР ТАНИЦЦУУЛСАН БАРИМТ

Иргэдийн оролцооны нэдэл нам

Төрийн аудитын тухай хуулийн 4.1.13-т "НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ" гэх аудит хийх явцад тухайн аудитын үр дүнтэй холбогдуулан төрийн аудитын байгууллагад аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх гэх оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталаажуулсан баримт бичгийг" ойлгоно гэж заасан.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитын байгууллагын албан хаагчид аливаа этгээдээс нөлөөлсөн бүх үйлдэлд Төрийн аудитын тухай хуулийн 39 дугаар зүйлийн 39.1-д заасны дагуу "НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ" хөтөнө.

НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ дурдсан мэдээллийг шалгуулах, хульд заасан хариуцлага ногдуулах асуудлыг Монгол Улсын Ерөнхий аудитор эрх бүхий байгууллага, албан тушаалтанц хандан шийдвэрлүүлж, энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тухай бурд нь нийтэд мэдээлтийн.

Төрийн аудитын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.9-д заасны дагуу аудитын байгууллагаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөвс нөлөөлсөн, дарамт, шахалт үзүүлсэн этгээдэд хуулийн хариуцлага хүлээгдэнэ.

Нэг. Шалгагдаач этгээдийг төлөөлж:²

№	Албан тушаал	Овог, нэр	Гарын үсэг	Огноо
1	Ерөнхий менежер	М.Манхцэцэг	Манхцэцэг	2025.03.07
2				
3				

Хоёр. Аудитын байгууллагыг төлөөлж:³

№	Албан тушаал	Овог, нэр	Гарын үсэг	Огноо
1	Гүйцэтгэх захирал	С.Энхтөр	С.Энхтөр	2025.03.07
2				
3				

² Шалгагдаач этгээдийн удирдах болон тухайн аудитад хамгаарах бусад албан тушаалтан
³ Аудитор эсвэл аудитын багийн алтагч

ААБ 2.5: Аудитын уулзалтын тэмдэглэл

Байгууллагын нэр: Иргэдийн оролцооны нэгдэл нам
Тайлант хугацаа: 2024 он

Төсвийн захиргачийн нэр: Уулзалт хийсэн газар, огноо, цаг:	Ерөнхий менежер М.Мөнхцэцэг
Уулзалтын зорилго:	Иргэдийн оролцооны нэгдэл намын 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх талаар
Шалгагдагч байгууллагын талаас:	Шалгагдагч байгууллагын талаас:
Уулзалтад оролцогчдын албан тушавал, нэр:	Ерөнхий менежер М.Мөнхцэцэг
Уулзалт, ярилцлагын товч утга:	Аудитын байгууллагын талаас:
Уулзалтын тэмдэглэсэн асуудлын аруулга:	Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Уулзалтын тэмдэглэл хөтөлсөн:	2024 оны санхүүгийн тайланд аудит хийх хуваарь, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг танилцуулав. Тайлант хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод хүчин зүйл, нягтлан болох бүртгэлийн бодлого, төсөв, санхүү, хөрөнгөнд гарсан үндсэн өөрчлөлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын талаар асууж тодруулав.
Шийдвэрлэсэн асуудлын аруулга:	Санхүүгийн тайланд завсрлын үеийн аудит хийх нөхцөл бололцоогоор хангах, шаардлагатай баримт материалыг саадгүй гаргаж өгөхөөр шийдвэрлэв.
Танилцсан:	